



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2019 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 10

Эрдэнэт

2019 онд ойгоос түлшний мод бэлтгэх
дээд хэмжээ батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2 дахь заалт, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэг, Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2018 оны А/299 дүгээр тушаалыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.2019 онд Жаргалант сумын ойн санд арчилгааны огтлолт хийх талбайн хэмжээг 20 га, ойн цэвэрлэгээгээр бэлтгэх хэрэглээний шинэс модны дээд хэмжээг 100 шоо метр, түлээний шинэс модны дээд хэмжээг 1400 шоо метрээр тус тус тогтоож баталсугай.

2.Холбогдох хууль, журмын дагуу ойгоос бэлтгэх модны төрөл, тоо хэмжээг нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага тус бүрээр тогтоохыг Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвшөөрсүгэй.

ДАРГА



П.ПҮРЭВЛХАГВА